

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газар



ЗАВХАНМАНДАЛ СУМЫН СУМ ДУНДЫН ЭМНЭЛГИЙН САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН,ЗӨВЛӨМЖ

Аудитын код: ЗАА-2018/139/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: 0

Тэргүүлэх аудитор: Л.Уламбаяр

Утас: 70463612, 99058189 Цахим хаяг: zavkhan@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Хашцэцэг

Утас: 70462813, 99019467, 98323586 Цахим хаяг: Khash_aud@yaoo.com

Аудитор: Г.Заяа

Утас: Цахим хаяг: gotovzaya@yahoo.com

Агуулга

| | | |
|-------|---|-------------------------------------|
| 1 | Аудитын гэрчилгээ | 2 |
| 2 | Аудитын тайлан | 3 |
| 2.1 | Оршил | 3 |
| 2.2 | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 3 |
| 2.3 | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 4 |
| 2.4 | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 4 |
| 2.5 | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 5 |
| 2.6 | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 5 |
| 2.7 | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 6 |
| 2.8 | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 6 |
| 2.9 | Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл | 7 |
| 2.9.1 | Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал | 7 |
| 2.9.2 | Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал | 7 |
| 2.9.3 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал | 7 |
| 2.9.4 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал | 7 |
| 2.10 | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 7 |
| 2.11 | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга | 7 |
| 2.12 | Шилэн дансны мэдээлэл | 8 |
| 2.13 | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга | 8 |
| 2.14 | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл | 9 |
| 3 | Менежментийн захидал | 9 |
| 3.1 | <u>«management_zurchil1»</u> | Error! Bookmark not defined. |
| 3.2 | <u>«management_zurchil2»</u> | Error! Bookmark not defined. |
| 4 | Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл | 15 |
| 4.1 | Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 15 |
| 4.2 | Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 15 |
| 4.3 | Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .. | Error! Bookmark not defined. |
| 4.4 | Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 15 |
| 4.5 | Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 15 |

1 АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2018.02.21 № 128
танай _____ -ны № _____ -г

ЗАВХАНМАНДАЛ СУМЫН СУМ ДУНДЫН
ЭМНЭЛГИЙН ЭРХЛЭГЧ А.ДУЛМАА-д

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 –д заасны дагуу Завханмандал сумын сум дундын эмнэлгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Завханмандал сумын сум дундын эмнэлгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Завханмандал сумын сум дундын эмнэлгийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.



Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

STB-2017

152 367

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Завханмандал сумын сум дундын эрхлэгч *А.Дулмаад* танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Завханмандал сум Сум дундын эмнэлгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Завханмандал сум Сум дундын эмнэлгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018-02-08 - наас 2018-02-15 – ны хооронд хийж, аудитын тайланг 2018-02-21 - нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Аудитор Г.Заяа хариуцаж хэрэгжүүлэв.

Завханмандал сум Сум дундын эмнэлгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2018-01-25 - нд төрийн аудитын байгууллагад 2018-01-11-ны өдрийн 02–р албан бичгээр ирүүлсэн байна.

2.2 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Завханмандал сум Сум дундын эмнэлэг “ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙНХЭЭ САНАА БОДОЛД НИЙЦСЭН ХҮРТЭЭМЖТЭЙ ТЭГШ ЧАНАРТАЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ” эрхэм зорилгын дор Эрүүл мэндийн газар-ийн эрхлэх асуудлын хүрээнд эмнэлгийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд Завханмандал сум Сум дундын эмнэлэг “1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, эх хүүхдийн өвчлөл эндэгдлийг бууруулах

2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл сурталчилгааны ажлыг эрчимжүүлж эрүүл зан үйлийг төлөвшүүлэх мэдлэг дадал хандлагыг нэмэгдүүлэх

3. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, тоног төхөөрөмжөөр хангах

4. Эрүүл ахуйн нөхцөл халдвараас сэргийлэх дэглэмийг сайжруулах

5. Эмнэлгийн алдаа зөрчил болон эрсдлээс сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх

6. Хүний нөөцийн хангалт эмч ажилчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, ажилчдын нийгмийн баталгааг хангах” дэвшүүлэн ажиллажээ.

Завханмандал сум Сум дундын эмнэлгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Завханмандал сум Сум дундын эмнэлгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

өөрчлөлт гараагүй

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Завханмандал сум Сум дундын эмнэлгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 2 буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах 2 гэж үзлээ.

Завханмандал сум Сум дундын эмнэлэг санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “aculous” програм хангамж ашиглажээ.

2.5 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Завханмандал сум Сум дундын эмнэлгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 23 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 2 асуудал эрсдэл өндөр гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-В-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 14 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 2 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.6 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн -ийг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь -тай холбоотой юм.

Завханмандал сум Сум дундын эмнэлгийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 307.4 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 3.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэл багатай холбоотой юм.

2.7 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 8 чиглэлээр 13 эрсдэлтэй асуудалд 13 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 70 хувь буюу 7 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

| № | Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал | Тоо | Дүн | Тайлбар |
|---|--|-----|-----|---------|
| 1 | Зөвлөмж болгосон асуудал | 2 | 1.2 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 1 | 0.6 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 0 | 0 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0 | |
| | Дүн | 3 | 1.8 | |

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.8 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

2.8.1 0,6 сая төлбөрийн акт тогтоосон нь Засгийн газрын 2012 оны 150 дугаар тогтоолыг зөрчиж шийдвэргүйгээр үр дүнгийн урамшуулал авсан асуудал бөгөөд энэ алдааг залруулаагүй

2.8.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй

2.8.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй

2.8.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

ээлжийн сувилагч нарын илүү цагийн олголт хуулийн дагуу биш байна

бараа материалын тайлан гаргаагүй, эд хариуцагчтай тооцоо бодоогүй, малын нас дэвшилтийн орлогыг хийгээгүй

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Завханмандал сум Сум дундын эмнэлэг өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 306.1 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
|-----|--|------------|-----------|------|-------|
| 1 | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 306.1 | 305.3 | 99.7 | -0.8 |
| 1.1 | Урсгал зардал | 306.1 | 305.3 | 99.7 | -0.8 |
| 1.2 | Хөрөнгийн зардал | 0 | 0 | 0.0% | 0.0 |
| 2 | Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр | 306.1 | 305.3 | 99.7 | -0.8 |
| 2.1 | Улсын төсвөөс санхүүжих | 305.3 | 305.3 | 100 | |
| 2.2 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | | | |
| 2.3 | Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос | 0,8 | 0 | | -0,8 |

Төсөвт зардлын гүйцэтгэл (99.7) хувь байгаа нь өөрийн орлого тасарсан холбоотой байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын биелэлт (0) хувь байгаа нь Өөрийн орлого олох үйл ажиллагаа явуулдаггүйтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар хөрөнгө хуваарилагдаагүй байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Завханмандал сум Сум дундын эмнэлэг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг *Завханмандал сум Сум дундын эмнэлэг 2018-01-11-ны өдрийн 01 дугаар албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.*

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Завханмандал сум Сум дундын эмнэлгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Завханмандал сум Сум дундын эмнэлгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь *Завханмандал сум Сум дундын эмнэлэг*-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Илрүүлэлт

Өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтанд аймгийн ЭМГ-аас хуулийн дагуу тэтгэмж олгосон байхад давхардуулан 0,5 сая төгрөгийн тэтгэмж олгон төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан. Тус эмнэлгийн орон тоо батлагдсан орон тооноос 2 ажилтнаар илүү ажиллаж байгаа, мэс заслын үйлчилгээг үзүүлдэггүйгээс эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авдаггүй ээлжийн сувилагч нарт илүү цагийн хөлсийг хуулийн дагуу олгоогүй байна.

Хариуцах ажилтан

Завханмандал сумын сум дундын эмнэлгийн эрхлэгч эмч А.Дулмаа
Нягтлан бодогч Л.Давхарбаяр

Эрсдэл

Хөрөнгө үрэлгэн зарцуулагдах

Зөвлөмж

-Мэс заслын эмчээр хангах хүсэлтийг Эрүүл мэндийн газарт тавьж шийдвэрлүүлэн, мэс заслын үйлчилгээг үзүүлэн эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авдаг болох

-Ээлжийн сувилагч нарт илүү цагийн хөлсийг хуулийн дагуу олгох, орон тооны илүү байгаа асуудлыг Эрүүл мэндийн газарт асуудал тавьж шийдвэрлүүлэх

- Өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтанд тэтгэмж давхардуулан олгож үрэлгэн зардал гаргадаг байдлыг таслан зогсоох

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

Илрүүлэлт

Зөвлөмж

- Эд хариуцагчийн болон нягтлан бодогчийн бараа материалын тайлан гаргалт хангалтгүй, нягтлан бодогч эд харицагчтай тооцоо бодож хэвшээгүй, удирдлагаас санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.
- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг мөрдөн санхүүгийн тайланг үнэн зөв гаргаж хэвших
- 2018 оны эхний улирлын санхүүгийн тайлан болон эд хариуцагчийн тайланг гарган, тооцоо нийлэн манай байгууллагаар хянуулах
- Бараа материалын орлого зардлыг үнэн зөв бүртгээгүйгээс үр дүнгийн болон бараа материалын тодруулга тайланг 0,4 сая төгрөгөөр буруу илэрхийлсэн
- Бараа материалын үлдэгдлийг 0,2 сая төгрөгөөр залруулах
- 0,2 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг буруу тайлагнасан
- Өгөгдсөн 6 зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 04 дүгээр сарын 15-ны дотор албан тоотоор ирүүлэх

Хариуцах ажилтан

Завханмандал сумын сум дундын эмнэлгийн эрхлэгч эмч А.Дулмаа
Нягтлан бодогч Л.Давхарбаяр

Эрсдэл

Төсвийн захирагчийн хариу

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх Хүлээн зөвшөөрсөн

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

Огноо: 2018-02-15

АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.ХАШЦЭЦЭГ

Огноо: 2018-02-15

БЭЛТГЭСЭН:

| | |
|---|--|
| <p>1.1 Асуудал 3: ЗАРДАЛ АУДИТОР</p> | <p>1.2 ТЭРГҮҮЛЭХ АХЧОЛБОГДОЛ №2 Г.ЗАЯА Огноо: 2018-02-14</p> |
| <p><u>ҮАГ-ынажиглалт</u></p> | <p><u>ҮАГ-ын зөвлөмж</u></p> |
| <p>1.4 Асуудал 3: ЗАРДАЛ төгрөг бусад орлогын 16.5 сая төгрөгийн орлогыг бууруулах бичилт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай мэдлийн 5 дүгээр сүйтийн 5.1.5</p> | <p>орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах 11 1.5 ТЭРГҮҮЛЭХ АХЧОЛБОГДОЛ №2</p> |

4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

- 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**
- 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**
- 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**
- 4.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**